


ШИВЭЭГОВЬ СУМЫН ЦАГ ҮЕИЙН МЭДЭЭ

\\2016.06.25-2016.07.25\\

НЭГ:УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

Сумын Засаг даргын А\74 дүгээр захирамжаар баяр наадмыг 2016 оны 07-р сарын 15, 16-ны өдөр зохион байгуулж, 6-н насны морь уралдан, шагайн харваачид болон сур харваачид онч мэргэнээ сорьлоо. Хүчит бөхийн барилдаанд 67 бөх барилдсанаас Говьсүмбэр “Аймгийн заан” Б.Мөнхбаатар түрүүлж, Шивээговь сумын харъяат, ШОХК-ийн бөх “Аймгийн начин” Б.Мөнхдорж үзүүрлэлээ.



Өргөдөл, гомдол, санал хүсэлт, шийдвэрлэлтийн мэдээ 2016 оны эхний хагас жилийн байдлаар Засаг дарга болон Засаг даргын Тамгын газарт 43 өргөдөл, 1, 2-р багт 7,


Иргэний бүртгэлийн асуудлаар 648, нийт 698 өргөдөл хүлээн авснаас 690 өргөдлийг хугацаанд нь шийдвэрлэж 8-н өргөдлийг шийдвэрлэх шатандаа явагдаж байна.



БОЛОВСРОЛ, СОЁЛ, ЭРҮҮЛ МЭНД, НИЙГМИЙН ХАМГААЛАЛ

ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВ :

- Эмнэлэгт хэвтсэн-32 үүнээс хүүхэд-9 халдварт-2, дотор-21
- Амбулаторийн үзлэг -236
- Урьдчилан сэргийлэх –46
- Дуудлага- 128
- Улсын хэмжээнд Тарваган тахлын дархлаажуулалтыг 2016 оны 07 сарын 18-28-ны хооронд зохион байгуулна. Эрүүл мэндийн төвд 80 хүний тун ирсэн бөгөөд вакцин хийх бэлтгэл ажлыг хийж эхлээд байна.
- Гар хөл амны өвчин, хордлого, гэдэсний хаодварт өвчин ихсэх хандлагатай байгаа тул НЭМА, Их эмч нар хамтран иргэдэд гарын авлага тараан зөвлөгөө өгч сургалт зохион байгуулан ажиллаж байна.



- Төрсний дараах нярайг 7, 14 хоногтоо тогтмол гэрийн эргэлтээр эргэдэг бөгөөд нярай хүүхэдтэй ээжүүдэд “Нярайн асаргаа” сэдэвт сургалтыг гэрийн эргэлтээр очин зөвлөгөө өгч гарын авлага тараан ажиллаж байна.



- Шивээговь сумын Эрүүл мэндийн төв, ЗДТГ-тай хамтран сумын нийт ахмадуудын дунд Ахмад настнуудыг дасгал хөдөлгөөнөөр эрүүлжүүлэх зорилгоор Иог хийн дасгал хичээллүүлэх ажлыг зохион байгуулж эхлээд байна.

ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ:

- Сумын 2016 оны ОНХС-ийн хөрөнгөөр хийгдэж буй “Өргөх станцын барилга, шугам хоолой, тоног төхөөрөмжийн их засварын ажлыг гүйцэтгэж дууссан хүлээлгэж өгөхөд бэлэн болоод байна.



- 3-р цэцэрлэгийн барилгын дээврийн засварын ажлын тендер зарлагдан “Чандмань” бүлэгтэй гэрээ байгуулан ажлыг эхлүүлээд байна.
- Сумын төвийн авто зам дагуу тарьсан модыг хашаажуулах ажилд “Үлэмж Тэмүүлэл” ХХК-тай гэрээ байгуулан ажлыг эхлүүлээд байна.
- Сумын “Хүндэтгэлийн хаалга хийх” ажлыг эхлүүлэн “Макс Майнд” ХХК-тай гэрээ байгуулаад байна.

НИЙГМИЙН ДААТГАЛ:

Эрүүл мэндийн шимтгэл, сайн дураар төлдөг иргэдээс хагас жилийн байдлаар 3.736.080 төгрөгийн орлого төвлөрсөн байна. Төрөөс эрүүл мэндийн даатгалд 172 иргэн үнэ төлбөргүй үйлчилгээ үзүүлсэн. Сайн дурын даатгалд шинээр 97 иргэн даатгуулснаас:

- Малчин иргэн-59
- Ажилгүй иргэн-26
- Хувиараа бизнес эрхлэгч-1
- Оюутан-11 тус тус шинээр даатгуулсан байна.

НИЙГМИЙН ХАЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХЭЛТЭС:

Амьжиргааг дэмжих зөвлөлийн хурлыг 2 удаа зохион байгуулан 10 иргэний өргөдөл ирснийг хэлэлцэн 100 хувь шийдвэрлэсэн.

Хүнсний эрхийн бичигт хамрагдаж буй 8 өрхийн 6-р сарын 455000 төгрөгийн хүнсний талоныг олгож гэрээ байгуулсан дэлгүүрээр дамжуулан хүнсний бүтээгдэхүүнийг олгосон.

2016 оны 06-р сарын 21-ээс 7-р сарын 22—ны өдрийг хүртэл 24 иргэний материал болон хувийн хэргийг программд шивж баталгаажуулан олголтыг хийлгэсэн. Үүнд:

- Жирэмсэн нярай хөхүүл эхийн тэтгэмжид – шинээр 1 иргэн
- Жирэмсэн нярай хөхүүл эхийн тэтгэмжийн сунгалт – 4 иргэн
- Хиймэл шүд хийлгэсэн – 1 хөгжлийн бэрхшээлтэй иргэн

- Хиймэл шүд хийлгэсэн – 1 ахмад настан
- Асаргааны мөнгөн тэтгэмжид – 5 иргэн
- Магадлан итгэмжлэгдсэн дотоодын рашаан сувилалд сувилуулсан ахмад настан – 1
- 2 хөлийн чиг бүхий аппарат хийлгэсэн хөгжлийн бэрхшээлтэй – 1 иргэн
- Тэргэнцэр авсан – 3 иргэн
- Нүдний уян болор суулгуулсан – 1 ахмад настан
- Бүрэн хараагүй иргэний харилцаа холбооны зардал – 1 хөгжлийн бэрхшээлтэй иргэн
- Сумын 2-р багийн иргэн Д.Отгончимэг, Л.Долгорсүрэн нар нь байнгын асаргаанд байдаг өөрсдөө явах чадваргүй, төлбөрийн боломжгүй учир аймгийн Нийгмийн халамжийн хэлтсээс тэргэнцэр авч өгөөд байна.